

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ

АУДИТЫН КОД: ӨМА-2025/06-15-ШТА-ГА

ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНТАЙ БОЛОХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Даланзадгад хот 2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn
Аудитор Н.Хулан
Утас: 70533552 Цахим хаяг: Khulann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлал.....	2
Хүснэгтийн жагсаалт.....	2
Дүрслэлийн жагсаалт.....	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	3
БҮЛЭГ А. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	5
А.1 Хүү, торгуулийн орлого татварын бус орлогод эзлэх хувь хэмжээ өмнөх оноос 7.8 хувиар нэмэгдсэн байна.....	5
А.2 Зарим төсвийн төвлөрүүлэн захирагч нар хүү, торгуулийн орлогыг гүйцэтгэлд үндэслэн төлөвлөөгүй байна.....	5
А.3 Хүү, торгуулийн орлогыг Төсвийн тухай хуульд заасны дагуу татварын бус орлогод төлөвлөж тайлагнасан байна.....	7
БҮЛЭГ Б. НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ОРЛОГООС 2023-2024 ОНД НИЙТ 5,232.8 САЯ ТӨГРӨГ ДУТУУ ТӨВЛӨРСӨН БАЙНА.....	9
Б.1. Эрх бүхий албан тушаалтнуудын 2024 онд ногдуулсан торгуулийн орлого төвлөрүүлэлт 2023 оноос 22.8 хувиар өссөн байна.....	9
Б.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд торгуулийн орлогыг хуваарилахдаа хуульд заасан хувь хэмжээг баримтлаагүй байна.....	12
БҮЛЭГ В. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА, ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....	13
В.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023-2024 онд нийт 1,924.5 сая төгрөг зарцуулсан байна.....	13
В.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг эрх бүхий байгууллагуудын санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэн шилэн дансны цахим хуудсаар мэдээлсэн байна.....	14
БҮЛЭГ Г. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БАЙХГҮЙ, ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРГИЙН БАЙГУУЛЛАГЫГ ХУУЛИАР ТОДОРХОЙЛООГҮЙ БАЙНА.....	15
Г.1 Хүү, торгуулийн орлого бүртгэлийн нэгдсэн бүртгэл мэдээллийн системийг бүрэн нэвтрүүлээгүй, мэдээллийн сан бий болоогүй байна.....	15
Г.2 Эрх бүхий байгууллагуудаас ногдуулсан торгуулийн хэрэгжилтэд нэгдсэн хяналт хэрэгжүүлэх чиг үүргийн байгууллагыг хуулиар тодорхойлоогүй байна.....	16
ДҮГНЭЛТ.....	18
ЗӨВЛӨМЖ.....	19
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгийн газар
СХДАГ	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
ӨМТАГ	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ААН	Аж ахуйн нэгж
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	Төсвийн орлогын ангилал	5
Хүснэгт 2	Торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	5
Хүснэгт 3	Хүүгийн орлогын гүйцэтгэл	6
Хүснэгт 4	Аймгийн торгуулийн орлогын ногдуулалт болон төвлөрсөн орлого	10
Хүснэгт 5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтийн мэдээлэл	12
Хүснэгт 6	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтийн мэдээлэл	13
Хүснэгт 7	Аймгийн торгуулийн орлогын ногдуулалт болон төвлөрсөн орлого	16

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх;
- Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлэх холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалыг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 3000-3200, 4000, Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төсвийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Нийгмийн даатгалын багц хуулиуд,
- Татварын багц хуулиуд,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль,

- Автозамын тухай хууль,
- Эрүүгийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль,
- Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль,
- Улсын бүртгэлийн тухай хууль,
- Иргэний хууль,
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль,
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль,
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль,
- Төрийн аудитын тухай хууль,
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”,
- Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам,
- Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”,
- Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”,
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”,
- Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Н.Хулан нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

БҮЛЭГ А. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1 Хүү, торгуулийн орлого татварын бус орлогод эзлэх хувь хэмжээ өмнөх оноос 7.8 хувиар нэмэгдсэн байна.

1.1 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь хэсэгт “... хүү, торгуулийн орлого” нь аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлогод хамаарахаар зохицуулагдсан.

1.2 Сангийн сайдын 2015 оны 07 дугаар тушаалаар баталсан төсвийн орлогын эдийн засгийн ангиллын дагуу татварын бус орлогын нийтлэг татварын бус орлогод хамаарч “хүү, торгуулийн орлого” гэсэн ангиллаар орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тайлагнагдаж байна.

Хүснэгт 1

Төсвийн орлогын ангилал				
Үзүүлэлт	(сая.төг)			
	2023 он		2024 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Татварын орлого	852,891.5	894,599.0	1,864,802.1	1,647,808.0
Татварын бус орлого	168,273.9	162,318.7	163,111.3	182,541.1
Хүү, торгуулийн орлого	4,155.8	5,095.1	17,037.9	20,002.6

Эх сурвалж: Нэгдсэн төсвийн гүйцэтгэл

1.3 Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харахад татварын бус орлогын /гүйцэтгэлээр/ 2023 онд 2.9, 2024 онд 10.7 хувийг хүү, торгуулийн орлого эзэлж байна.

1.4 Энэ нь татварын бус орлогод эзлэх хувь нэмэгдэж байгаа нь хүү, торгуулийн орлогын хэрэгцээ шаардлага нэмэгдэж байгааг харуулж байна.

А.2 Зарим төсвийн төвлөрүүлэн захирагч нар хүү, торгуулийн орлогыг гүйцэтгэлд үндэслэн төлөвлөөгүй байна.

1.5 Аймаг, сумын төсвийн орлогыг “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д зааснаар төсвийн төсөлд орлогыг нэр, төрлөөр тооцож, төлөвлөхөөр зохицуулсан байдаг.

1.6 Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчид нь аймаг, сумын торгуулийн орлогыг төлөвлөж, шат шатны ИТХ-аар батлуулсан байна. Аймаг сумдын ИТХ-ын тогтоолд 2023 онд 4,211.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 4,800.4 сая төгрөгийн, 2024 онд 16,592.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 19,563.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2 Торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

№	Сумд	2023 он		2024 он	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Баяндалай	6.6	8.5	5.5	7.0

2	Баян-овоо	267.0	268.5	202.0	229.2
3	Булган	4.1	4.0	4.1	5.7
4	Гурвантэс	50.0	798.1	2,980.0	3,179.2
5	Даланзадгад	810.0	1,251.3	680.0	1,785.3
6	Мандал-Овоо	1.1	0.1	4.1	0.5
7	Манлай	20.0	34.5	25.0	27.3
8	Ноён	3.1	223.2	4.1	323.1
9	Номгон	1.1	3.7	4.1	4.2
10	Сэврэй	4.1	5.3	4.1	2.6
11	Ханбогд	455.2	689.6	2,955.2	3,265.6
12	Ханхонгор	47.1	83.0	37.1	62.6
13	Хүрмэн	-	2.8	4.1	-
14	Цогт-Овоо	55.0	-	54.1	1.5
15	Цогтцэций	450.0	689.8	8,570.0	9,302.6
16	Аймаг	2,036.6	738.0	1,058.7	1,366.7
	Нийт	4,211.0	4,800.4	16,592.2	19,563.0

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.7 Хүн амын тоо болон эдийн засгаас шалтгаалан 500.0 сая төгрөгөөс дээш торгуулийн орлогын төлөвлөгөө баталсан 4 сум байна. Тухайлбал 2024 онд Гурвантэс сум 2,980.0 сая төгрөг, Даланзадгад сум 680.0 сая төгрөг, Ханбогд сум 2,955.2 сая төгрөг, Цогтцэций сум 8,570.0 сая төгрөгийн торгуулийн орлогын төлөвлөгөөг тус тус баталсан байна.

1.8 Торгуулийн орлого аймгийн хэмжээнд 2023 онд 114 хувь, 2024 онд 118 хувиар давж биелсэн байна. Энэ нь торгуулийн орлогыг төлөвлөхдөө орлого төвлөрүүлэгч байгууллагуудын санал, төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл, тооцоо судалгаа, эх үүсвэрийг бодитой тодорхойлоогүйг харуулж байна.

1.9 Харин хүүгийн орлогыг аймаг, сумд төлөвлөөгүй байна.

Хүснэгт 3 Хүүгийн орлогын гүйцэтгэл

№	Сумд	/сая.төг/	
		2023 он гүйцэтгэл	2024 он гүйцэтгэл
1	Баяндалай	-	7.0
2	Баян-овоо	30.8	-
3	Булган	-	-
4	Гурвантэс	-	-
5	Даланзадгад	-	53.4
6	Мандал-Овоо	-	0.5
7	Манлай	-	-
8	Ноён	-	323.1
9	Номгон	33.2	43.4
10	Сэврэй	-	-
11	Ханбогд	193.9	-
12	Ханхонгор	6.8	12.4
13	Хүрмэн	-	-
14	Цогт-Овоо	30.1	-

15	Цогтцэций	-	-
16	Аймаг	-	-
	Нийт	294.7	439.7

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.10 Дээрх хүүгийн орлого нь зарим нь торгуулийн орлого, иргэдийн хадгаламжийн хүүд ногдуулсан татварын орлогыг буруу тайлагнаснаас үүссэн орлого байна. Энэ сумдын санхүү албаны даргын алдаанаас шалтгаалсан байна.

1.11 Иймд дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг зөрчил гаргасан сумдын Засаг дарга, санхүү албаны дарга нарт хүргүүлээ.

1.12 Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Энэ хууль 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал үйлчилнэ” гэж заасан байна. Монгол банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А-7/8/4 дүгээр “Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай” тушаалын 1-д Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг жилийн 3 хүртэл хувиар тогтоосугай” гэж заасан байна.

1.13 Гэвч орон нутгийн оролцоотой аж ахуй нэгж, компани болон орон нутгийн өмчит газруудын харилцах дансны үлдэгдэлд хүү тооцоогүй байна.

1.14 Эх үүсвэрийг хуулийн хүрээнд нэмэх, торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар сумдын Засаг дарга нар бодиттой арга хэмжээ авч ажиллаагүй байна. Цаашид төсөв боловсруулж батлахдаа хүү, торгуулийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг судлан арга хэмжээ авч орон нутгийн хөгжилд оруулах хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

А.3 Хүү, торгуулийн орлогыг Төсвийн тухай хуульд заасны дагуу татварын бус орлогод төлөвлөж тайлагнасан байна.

1.15 Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомжийн нийцлийг үзэхэд дараах байдлаар зарим зүйл заалтууд нь зөрчилдөж байна. Үүнд:

- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд...Зөрчлийн тухай хуулийн ...14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7, 15.1 дүгээр зүйл... заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн

төсөвт тусгаж, санхүүжүүлнэ. Харин Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ын 2.5.4. нийслэл, орон нутгийн авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгуулийг тухай бүр нийслэл, орон нутгийн авто замын сангийн тусгай дансанд гэсэн байна.

- Татварын ерөнхий хуулийн 53 дугаар зүйлийн 53.1."Доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүсэж татвар төлөгч татварын өрийг төлөх боломжгүй болох нь тогтоогдсон бол татвар төлөгчийн бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн харьяа татварын алба татвар төлөх хугацааг 1 жил хүртэлх хугацаагаар сунгаж хөнгөлөлт үзүүлж болно". Харин Зөрчлийн тухай хуулийн 2.3."татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд татварын албанд тушаах" гэсэн байна.

1.16 Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтэд сөрөг нөлөөлж буй дараах хууль эрх зүйн заалтууд байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлэх, хуваарилах, хяналт тавих аргачлалыг тусгайлан зааж өгөөгүй байна. Мөн хүү, торгуулийг нэгтгэн төлөвлөж тайлагнадаг,
- Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 4.2.17¹, 4.2.28² -т гэж заасан боловч татварын бус орлого буюу торгуулийн орлогын төлөвлөлтийн талаар тодорхой тусгаагүй,
- "Татварын ерөнхий хууль"-д татварын орлогыг хэрхэн бүрдүүлэх, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх зэрэг үйл ажиллагааг зохицуулдаг. Гэвч энэ хуульд торгуулийн орлогыг хэрхэн бүрдүүлэх хяналт тавих талаар тодорхойгүй,
- "Зөрчлийн тухай хууль"-д зааснаар, зөрчил үйлдсэн этгээдэд торгууль ногдуулах, албадлагын арга хэмжээ авах зэрэг зохицуулалтууд байдаг. Гэвч энэ хуульд торгуулийн орлогыг хэрхэн бүрдүүлэх, түүнийг төсөвт хэрхэн төвлөрүүлэх талаар тодорхойгүй байна.

1.17 Аймаг, сумдын торгуулийн орлого бүрдүүлж байгаа байгууллагуудаас цагдаагийн байгууллагын торгуулийн орлогыг тулгахад шийдвэрийн хуудсаар тогтоосон торгуулийн орлого нь орон нутгийн нэгдсэн дансанд төвлөрүүлж байгаа ч бэлэн бусаар торгосон тохиолдолд smartcar, gerege, e-mongolia, toki, torguuli.mn банк зэргээр төлөгдөж байна.

1.18 Торгууль төлж байгаа иргэн аж ахуйн нэгжүүд нь торгууль төлөхдөө нэр, регистр болон холбогдох хувийн мэдээллээ дутуу оруулж төвлөрүүлснээс мөн цагдаагийн байгууллага нь зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгжүүдийн зөрчлийг программаас ногдуулалт, төвлөрүүлэлтийг зөрчлийн ангиллаар нь шүүж гаргадаг ч

¹ "орон нутгийн төсвийн нийт орлогыг орон нутгийн төсвийн суурь орлого болон хуулиар эрх олгосны дагуу тухайн орон нутагт татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгосон орлогын нийлбэрээр;"

² "орон нутгийн төсвийн суурь орлогыг тухайн шатны төсөвт орох Улсын Их Хурлаас тогтоосон татварын доод хувь, хэмжээгээр тооцсон татварын болон татварын бус орлогын нийлбэрээр;"

тус программын хувьд тухайн оны торгууль тогтоосон орлого болон төвлөрүүлсэн нь мэдэгдэхээс, өмнөх оноос хэдэн төгрөгийн орлого, хэнээс орсныг бүрэн тулгах боломжгүй байгаа нь хүндрэл үүсгэж байна.

1.19 Мөн торгуулийн орлого бүрдүүлэлтэд дараах тодорхойгүй асуудлууд нөлөөлж байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд торгуулийн орлогын бүрдүүлэлтийг нарийвчлан тусгах, хяналт тавьж хэрэгжилтийг хангах эрх бүхий байгууллага албан тушаалтныг тодорхойлоогүй.
- Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд торгуулийн орлогыг төлөвлөх, ямар арга хэмжээнд зарцуулах талаар тодорхой тусгаагүй
- Хүү торгуулийн орлогыг хуваарилах аргачлал байхгүй байна.

1.20 Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, бүртгэх бүх шатанд нэгдсэн хяналт хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй ба одоогийн байдлаар торгууль ногдуулсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан хэрэгжилтийг хариуцан хангуулж байна.

БҮЛЭГ Б. НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙН ОРЛОГООС 2023-2024 ОНД НИЙТ 5,232.8 САЯ ТӨГРӨГ ДУТУУ ТӨВЛӨРСӨН БАЙНА.

Б.1. Эрх бүхий албан тушаалтнуудын 2024 онд ногдуулсан торгуулийн орлого төвлөрүүлэлт 2023 оноос 22.8 хувиар өссөн байна.

2.1. Монгол Улсын Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтны хэрэгжүүлэх чиг үүргийг салбар тус бүрийн хуулиар тодорхойлж өгсөн байна.

2.2. Орон нутгийн төсөвт торгуулийн орлого төвлөрүүлдэг аймгийн төсвийн байгууллагуудын болон 15 сумын нийт 24 данс байна. Эдгээр дансанд төвлөрсөн торгуулийн орлогыг төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд тусгаж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэн тайлагнаж байна. Дансны ерөнхий ангиллыг харуулбал:

- 952, 956 – Татварын торгууль
- 982 – Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
- 988 – Цагдаагийн газар, бусад

2.3. Хүү, торгуулийн орлого нь орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлдэг орлогын нэг төрөл бөгөөд эдгээр орлогыг хуваарилах чиг үүрэг нь аймгийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагч, сумдын хувьд төсвийн төвлөрүүлэн захирагчид байна.

2.4. Аймгийн 2023-2024 оны торгуулийн орлогын 93 хувийг Цагдаагийн газар, Татварын газрын торгуулийн орлого, 7 хувийг Аймгийн ЗДТГ, Байгаль орчны газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, Гадаадын иргэн харьяатын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Төрийн аудитын газар, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын торгуулийн орлого эзэлж байна.

Хүснэгт 4 Аймгийн торгуулийн орлогын ногдуулалт болон төвлөрсөн орлого /сая. төг/

Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	2023 он			Эзлэх хувь	2024 он			Эзлэх хувь
	Ногдуулсан	Төвлөрсөн	Зөрүү		Ногдуулсан	Төвлөрсөн	Зөрүү	
Аймгийн ЗДТГ	14.5	13.3	1.2	0.1	119.2	75.2	44.0	1.6
Татварын газар	3,730.6	2,099.4	1,631.2	64.8	17,998.9	15,742.7	2,256.2	83.1
Цагдаагийн газар	2,905.4	2,096.5	808.9	32.1	2,514.8	2,670.2	-	-
Байгаль орчны газар	57.7	53.1	4.6	0.1	256.2	220.4	35.8	1.3
СХДАГ	147.3	118.2	29.1	1.3	316.2	123.2	193.0	7.1
ГИХГ	31.8	31.8	-	-	75.4	75.4	-	-
Улсын бүртгэлийн хэлтэс	18.0	18.0	-	-	22.8	22.8	-	-
ӨМТАГ	163.3	126.1	37.2	1.5	270.1	138.5	131.6	4.9
ГХБХБГ	38.3	33.3	5.0	0.1	288.3	233.3	55.0	2.0
ШШГГ	210.7	210.7	-	-	261.3	261.3	-	-
Нийт дүн	7,317.6	4,800.4	2,517.2	100	22,123.2	19,563.0	2,715.6	100

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

2.5. Торгуулийн орлогын биелэлтийн хувийг тооцож үзвэл 2023 онд 65.6 хувь, 2024 онд 88.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.6. Торгуулийн орлогын ногдуулалт, төвлөрүүлэлт 2024 онд 2023 оноос 407.5 хувиар өссөн байна. Аймгийн Засаг даргын 2023 оны 11-р сарын 13-ны өдрийн А/2094 тоот захирамжаар, аймгийн ИТХ-ын 2023 оны 15/11 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх, орон нутгийн төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлэх, төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх үе шаттай ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг Аймгийн Засаг даргын орлогч даргаар ахлуулан байгуулсан байна.

2.7. Ажлын хэсэг 2024 онд Уул уурхайн ААН-үүдээр татварын ногдол, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийсэн нь торгуулийн орлого өсөхөд голлох нөлөө үзүүлсэн байна.

2.8. Харин Хүнс хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, Мал эмнэлгийн газар, Нийгмийн даатгалын газар болон бусад босоо байгууллагууд нь харьяа яамны торгуулийн дансанд орлого төвлөрүүлдэг байна.

2.9. Зөрчлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т заасан эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан торгуулийн шийтгэлийн хуудсыг Засгийн газрын 2021 оны 135, 2024 оны 38 дугаар тогтоолуудаар баталсан маягтын дагуу аймгийн Прокурорын газарт хүргүүлж хянуулдаг байна.

2.10. Аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар зөрчил хянан шийдвэрлэх 27 байгууллагын 313 торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтан байна. Үүнд:

- Цагдаагийн газар 67,
- Шивээ хүрэн дэх гаалийн газар 49,
- Татварын газар 36,
- Хилийн цэргийн 166 дугаар анги 29,
- Хилийн цэргийн 131 дүгээр анги 19,
- Нийгмийн даатгалын газар 15,
- ГИХГ 12,
- Аймгийн ЗДТГ 11,
- Мал эмнэлгийн газар 11,
- Байгаль орчны газар 10,
- Онцгой байдлын газар 6,
- Говь Гурвансайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа 5,
- Тагнуулын газар 4,
- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 4,
- Статистикийн хэлтэс 4,
- Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар 4,
- Дотоодын цэргийн 827 дугаар тусгай салбар 4,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 4,
- Монгол банк 3,
- Хүнс, хөдөө аж ахуйн газар 3,
- Эрүүл мэндийн газар 3,
- Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар 3,
- Стандарт хэмжил зүйн хэлтэс 3,
- Улсын бүртгэлийн газар 2,
- Боловсролын газар 1,
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар 1,
- Авто тээврийн төв 1 байна.

2.11. Аймгийн хэмжээнд уул уурхайн компаниудтай холбоотой хоолны хордлого болон бусад зөрчил маргаан нэлээдгүй их гардаг боловч хяналт тавих, зөрчил таслан зогсоох эрх бүхий албан тушаалтны хүний нөөц дутмаг байгаа нь зөрчлийн илрүүлэлт, давтамж буурахгүй байгаа нэг шалтгаан болж байна.

2.12. Гэтэл зарим торгуул ногдуулах эрх бүхий албан тушаалтан нь аудитыг хамарсан 2023-2024 онд огт торгуул ногдуулаагүй байна. Тухайлбал: Цэргийн штаб,

Боловсролын хяналтын улсын байцаагч, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс зэрэг байна.

2.13. Иймд зөрчлийн тоо, төсөвт төвлүүлдэг орлогын хувь хэмжээ болон ажлын ачаалал зэргийг харгалзан дүгнэлт хийж эрх бүхий албан тушаалтнуудыг нэмэгдүүлэх, бууруулах шаардлагатай байна.

2.14. Аудитаар торгуулийн орлогын дансанд төвлөрсөн дүнг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон Засгийн газрын санхүүгийн “Э-тайлан” төсвийн гүйцэтгэлийн системд тусгасан дүнтэй тулган баталгаажуулахад зөрүү илрээгүй болно.

Б.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд торгуулийн орлогыг хуваарилахдаа хуульд заасан хувь хэмжээг баримтлаагүй байна.

2.15. Аймгийн орон нутгийн төсөвт төвлөрөх торгуулийн орлогоос авто замын хөрөнгө оруулалт болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг санхүүжүүлэхээр аймгийн ИТХ-ын тогтоолоор баталжээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг санхүүжүүлэх төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтийн мэдээлэл /сая. төг/

Он	АИТХ	АЗДТГ	Сумын ИТХ	Сумын ЗДТГ	Нийт
	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө
2023	258.0	582.4	77.4	180.8	1,098.6
2024	258.0	582.4	78.3	195.6	1,114.3
Дүн	516.0	1,164.7	155.8	376.4	2,212.8

Эх сурвалж: СТСХ

2.16. Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль”-ийг авто замын санд, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан зөрчлүүдэд оногдуулсан торгох шийтгэлээс төсөвт төвлөрсөн орлогын 40-өөс доошгүй хувийг дараагийн төсвийн жилд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар заасан байна.

2.17. Хүснэгтээс харахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023 онд 1,098.6 сая төгрөг, 2024 онд 1,114.3 сая төгрөг төлөвлөсөн байна. Энэ нь Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалттай нийцэхгүй байна.

2.18. Харин Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-д заасны дагуу авто замын санд төвлөрүүлэх хөрөнгө оруулалтыг 2023 онд 9,500.0 сая төгрөг, 2024 онд 10,987.2 сая төгрөг тус тус хуваарилан баталжээ.

2.19. Торгуулийн орлогыг замын сангийн хөрөнгийн эх үүсвэр болгохоор хуульчилсан боловч уг орлогыг төсвийн нийт эх үүсвэрт нэгтгэн оруулж, бөөн дүнгээр хуваарилдаг тул торгуулийн орлогоос замын санд хэдэн төгрөгийг хуваарилсныг хянах боломжгүй байна.

БҮЛЭГ В. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА, ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

В.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023-2024 онд нийт 1,924.5 сая төгрөг зарцуулсан байна.

3.1 Хүү, торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд аймгийн ИТХ, ЗДТГ, 15 сумын ИТХ, ЗДТГ-ууд 2023 онд 958.6 сая төгрөг, 2024 онд 965.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 6 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтийн мэдээлэл /сая. төг/

Он	АИТХ		АЗДТГ		Сумын ИТХ		Сумын ЗДТГ		Нийт	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2023	258.0	227.7	582.4	481.5	77.4	68.8	180.8	180.6	1,098.6	958.6
2024	258.0	231.5	582.4	481.1	78.3	64.9	195.6	188.4	1,114.3	965.9
Дүн	516.0	459.2	1,164.7	962.6	155.8	133.7	376.4	369.0	2,212.8	1,924.5

Эх сурвалж: СТСХ

3.2 Дээрх санхүүжилтийг тухай байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон бөгөөд зарцуулалтын эрхийг зохих журмын дагуу эрх нээлгэж зарцуулсан байна.

3.3 Төрийн аудитын газраас зарцуулалтад жил бүрийн санхүүгийн тайлангийн аудит хийгдэж тухайн байгууллагын дүгнэлт, аудитын шийдвэрийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн зорилго нь “Өмнөговь аймагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг нэгдмэл удирдлага, нэгдсэн бодлогоор уялдуулан зохион байгуулж, хүний эрх, эрх чөлөө, төр, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн дэг журмыг бэхжүүлж, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээний явц, үр дүнд хяналт тавьж, санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд оршино” гэжээ.

3.5 Тус зорилгыг хангахын тулд дараах 3 зорилт дэвшүүлсэн байна. Үүнд:

- Өмнөговь аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрд хүрч холбогдох хууль, тогтоомжийг сурталчлах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтийг татан оролцуулах,
- Гэмт хэргийн гаралт ихэссэн нутаг дэвсгэрт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт өмнөх онд

бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ, дүн шинжилгээнд дурдагдсан өмнөх онд өссөн Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, Архидан согтуурснаас үйлдэлтэй гэмт хэрэг, зөрчил, хүний амь эрүүл мэнд, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах,

- Сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, зөвлөмж өгч ажиллах.

3.6 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 2023 онд 31 арга хэмжээ, 2024 онд 12 арга хэмжээ тус тус төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

3.7 Тус арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр 2024 оны байдлаар гэмт хэрэг зөрчлийн нөхцөл байдал дараах байдалтай байна. Үүнд:

- Нийт гэмт хэрэг 2024 оны байдлаар 790 бүртгэгдсэн байна.
- Аймгийн хэмжээнд 2023 оны 12 дугаар сарын байдлаар 77,946 зөрчил гарч байсан бол 2024 оны 12 дугаар сарын байдлаар 72,260 зөрчил гарсан байна.
- Аймгийн хэмжээнд 2023 оны 12 дүгээр сарын байдлаар 725 гэмт хэрэг гарч байсан бол 2024 оны 12 дугаар сарын байдлаар 790 гэмт хэрэг гарсан байна.
- Аймгийн хэмжээнд 2023 оны 12 дугаар сарын байдлаар 77946 зөрчил гарсан нь, 2024 оны 12 дугаар сартай харьцуулахад 5,686 нэгжээр буюу 7,3 хувиар буурсан байна.
- Аймгийн хэмжээнд 2023 оны 12 дугаар сарын байдлаар 725 гэмт хэрэг гарсан нь, 2024 оны 12 дугаар сартай харьцуулахад 65 нэгжээр буюу 8,2 хувиар өссөн байна.
- Гэмт хэрэг, зөрчлийн улмаас 2023 оны 12 дугаар сарын байдлаар 26,015.5 сая төгрөгийн хохирол учирсан нь 2024 оны 12 дугаар сартай харьцуулахад 17,661 нэгжээр буюу 67,8 дахин буурсан байна.
- 2023 оны 12 дүгээр сард 725 гэмт хэрэг гарч түүний 52,3 хувийг ирүүлсэн, 2024 оны 12 дугаар сарын байдлаар 790 гэмт хэрэг гарч түүний 60,5-ийг илрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад илрүүлэлтийн хувь 8,2 хувиар өссөн байна.

3.8 Хэдийгээр гэмт хэргийн гаралт болон зөрчилд тодорхой хэмжээний эерэг өөрчлөлт гарсан ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зарцуулалтаар хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг дүгнэх боломжгүй байна

В.2 Хүү, торгуулийн орлогын зарцуулалтыг эрх бүхий байгууллагуудын санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэн шилэн дансны цахим хуудсаар мэдээлсэн байна.

3.9 Аймаг, сумдын Засаг дарга нар тухайн жилийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэлийн мэдээг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.5-д заасны дагуу шилэн дансны сайтад улсын төсөв болон орон

нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл цэсэд сар бүр мэдээлж ажилласан байна.

3.10 Мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн зарцуулалтыг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.2-т заасны дагуу хугацаанд нь мэдээлсэн байна.

3.11 Аймгийн хэмжээнд торгуулийн орлогын зарцуулалтыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж, аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл мэдээ, тайланг нэгтгэн ажилласан байна

3.12 Гэмт хэргээс хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан байгууллагууд мэдээ, тайланг өөрийн цахим хуудас болон Facebook хаяг, ГХУССЗөвлөл нь мөн өөрийн пэйж хаяг, omnogovi.khural.mn сайтын ГХУССЗ цэс болон орон нутгийн “Алтан говь” телевизтэй хамтран, цахим орчноор дамжуулан олон нийтийг мэдээллээр хангаж ажилладаг байна

3.13 Хүү, торгуулийн орлогын зарцуулалттай холбоотойгоор иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талуудаас үнэлгээ, санал, дүгнэлт гаргаж байгаагүй байна.

БҮЛЭГ Г. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БАЙХГҮЙ, ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРГИЙН БАЙГУУЛЛАГЫГ ХУУЛИАР ТОДОРХОЙЛООГҮЙ БАЙНА.

Г.1 Хүү, торгуулийн орлого бүртгэлийн нэгдсэн бүртгэл мэдээллийн системийг бүрэн нэвтрүүлээгүй, мэдээллийн сан бий болоогүй байна.

4.1 Зөрчил, торгууль, шийтгэлийн мэдээллийг нэгтгэн бүртгэх, байгууллага хооронд мэдээлэл солилцох, орлого бүрдүүлэлтийн хэрэгжилтийг хангах нэгдсэн бүртгэл, хяналтын систем байхгүй байна. Байгууллага тус бүр өөрийн салбарын бүртгэлийн программ хангамжийг ашигладаг ба зарим байгууллагад бүртгэлийн цахим систем огт ашигладаггүй байна. Тухайлбал:

- Нийгмийн даатгалын газар SIGOS системд орлогыг бүртгэж, НДЕГ-ын хэмжээнд нэгдсэн сан үүсгэдэг,
- Гаалийн газар Кайс системээр орлогыг бүртгэж ГЕГ-ын орлогын газарт нэгдсэн сан үүсгэдэг,
- Аймгийн ЗДТГ- болон бусад байгууллагуудын ЭБАТ-уудад орлогыг бүртгэх систем байдаггүй байна.

4.2 Энэ нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсанаар системийн үндсэн хэрэглэгч, зохион байгуулах бүтэцгүй болж салбарын хяналтын нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах үүрэгтэй байгууллага, албан тушаалтан тодорхойгүй болсон байна.

4.3 Нэгдсэн бодлого, системгүйгээс тухайн байгууллагын тогтоосон торгуулийн орлогыг аймгийн СТСХ, сумдын санхүү алба орлогын гүйцэтгэлийг хянах, мэдээлэл боловсруулахад хүндрэл үүсгэж байна.

4.4 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлд зааснаар зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээд торгуулийг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр төлөх зохицуулалттай хэдий ч, аудитын явцад цуглуулсан мэдээллээс харахад эрх бүхий албан тушаалтнуудын шийтгэврийн мэдээлэл нь нэгдсэн бүртгэлд бүрэн нэгтгэгддэггүйгээс зарим төрлийн торгуулийг цахимаар төлөх нөхцөл хангагдаагүй байна.

4.5 Замын хөдөлгөөний зөрчлийн торгуулийг төлөх боломжийг хангах зорилгоор e-Mongolia, SmartCar, Гэрэгэ киоск, банкны интернэт болон мобайл банкны аппликейшн зэрэг төлбөрийн цахим сувгууд өргөн ашиглагдаж байна. Замын цагдаагийн байгууллагаас ногдуулсан торгуулийн мэдээлэл тус бүрийг дахин давтагдашгүй дугаар, бар кодоор тэмдэглэж, төлөлтийн явцад хяналт тавих, торгуулийн биелэлтийг тооцох нөхцөл бүрдүүлж, цагдаагийн байгууллагын хувьд системийн хэрэгжилтийг хангалттай хэмжээнд хэрэгжүүлж байна.

Г.2 Эрх бүхий байгууллагуудаас ногдуулсан торгуулийн хэрэгжилтэд нэгдсэн хяналт хэрэгжүүлэх чиг үүргийн байгууллагыг хуулиар тодорхойлоогүй байна.

4.6 Аймгийн хэмжээнд сүүлийн 2 жилийн байдлаар хугацаа хэтэрсэн нийт 5,232.8 сая төгрөгийн торгуулийн авлагын үлдэгдэл байна.

Хүснэгт 7 Аймгийн торгуулийн орлогын ногдуулалт болон төвлөрсөн орлого /сая. төг/

Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	2023 он			Эзлэх хувь	2024 он			Эзлэх хувь
	Ногдуулсан	Төвлөрсөн	Зөрүү		Ногдуулсан	Төвлөрсөн	Зөрүү	
Аймгийн ЗДТГ	14.5	13.3	1.2	0.1	119.2	75.2	44.0	1.6
Татварын газар	3,730.6	2,099.4	1,631.2	64.8	17,998.9	15,742.7	2,256.2	83.1
Цагдаагийн газар	2,905.4	2,096.5	808.9	32.1	2,514.8	2,670.2	-	-
Байгаль орчны газар	57.7	53.1	4.6	0.1	256.2	220.4	35.8	1.3
СХДАГ	147.3	118.2	29.1	1.3	316.2	123.2	193.0	7.1
ӨМТАГ	163.3	126.1	37.2	1.5	270.1	138.5	131.6	4.9
ГХБХБГ	38.3	33.3	5.0	0.1	288.3	233.3	55.0	2.0
Нийт дүн	7,317.6	4,800.4	2,517.2	100	22,123.2	19,563.0	2,715.6	100

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

4.7 Торгуулийн орлогын авлагын он тус бүрийн 64.8-83.1 хувийг Татварын газрын авлага эзэлж байна. Энэ нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 1, 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасантай нийцэхгүй байна.

4.8 Аймгийн Татварын газрын татварын хяналт шалгалтын тасаг нь Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу татвар төлөгчийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг хянах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийж хяналт шалгалтыг зохион байгуулсан байна.

4.9 Албан хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэд ноогдуулсан торгуулийн биелэлтийг харгалзан үзэхгүй байгаа нь эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэл, хариуцлагыг бууруулж байна.

4.10 Аймгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад санхүүгийн болон хууль зүйн түвшний хяналт хэрэгжүүлэхээр салбар тус бүрийн хуулиар тодорхойлсон байна.

4.11 Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, санхүү төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба нь санхүүгийн гүйцэтгэлийг хянах чиг үүрэгтэй байна.

4.12 Прокурорын байгууллагаас 2023, 2024 онд хэрэгжүүлсэн эрх бүхий албан тушаалтны тавьсан торгуулийн үндэслэл болон гомдол маргаанд дараах хяналт хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байна.

4.13 Засгийн газрын 2021 оны 134 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам"-ыг боловсруулсан байна. Тус журамд заасны дагуу шийтгэлийн хуудас буюу үнэт цаасыг аймгийн санхүү төрийн сан хариуцан бүртгэлээр олгож, тооцоо бодож, тайлагнах үүрэгтэй байна.

4.14 Эрх бүхий байгууллага нь шийтгэлийн хуудсыг олгох, тайлан тооцоо хийх үүрэг бүхий албан тушаалтныг томилж, түүнийг үнэт цаасны нэгэн адил бүртгэж, хадгалалт хамгаалалт, зарцуулалтад тухайн байгууллагын дарга, нягтлан бодогч хяналт тавих чиг үүрэгтэй байна.

4.15 Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэс нь шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягтыг эрх бүхий байгууллагад олгох, тайлан мэдээг хүлээн авч, тооцоо нийлэх үйл ажиллагаанд бүрэн хяналт тавиагүй, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шийтгэлийн хуудасны тооцоог бэлтгэж хүргүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.14 -т заасанд нийцэхгүй байна.

4.16 Иргэн, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас торгуулийн орлогын бүрдүүлэлт зарцуулалтад хяналт, үнэлгээ, дүгнэлт хийгээгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хүү, торгуулийн орлого татварын бус орлогын /гүйцэтгэлээр/ 2023 онд 2.9, 2024 онд 10.7 хувийг хүү, торгуулийн орлого эзэлж байна.
- Аймгийн 2023-2024 оны торгуулийн орлогын 93 хувийг Цагдаагийн газар, Татварын газрын торгуулийн орлого, 7 хувийг Аймгийн ЗДТГ, Байгаль орчны газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, Гадаадын иргэн харьяатын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Төрийн аудитын газар, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын торгуулийн орлого эзэлж байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023 онд 1,098.6 сая төгрөг, 2024 онд 1,114.3 сая төгрөг төлөвлөсөн байна.
- Аймгийн хэмжээнд сүүлийн 2 жилийн байдлаар хугацаа хэтэрсэн нийт 5,232.8 сая төгрөгийн торгуулийн авлагын үлдэгдэл байна.
- Иргэн, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас торгуулийн орлогын бүрдүүлэлт зарцуулалтад хяналт, үнэлгээ, дүгнэлт хийгээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Н.Энхбат танаа:

- Торгууль тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын ногдуулсан торгуулийн нэгдсэн санг бий болгон жил бүр тооцоо нийлэх, төсвийн төлөвлөлтөд ашиглах

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/22

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, Өмнөговь аймгийн Засаг дарга, сумдын засаг дарга нарт тус тус хүргүүлэхийг Ахлах аудитор (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг Аудитор (Н.Хулан)-т, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг Ахлах аудитор (Г.Шижирболд)-д даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

